

## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН 23 ДУГААР ХУРАЛ

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 23 дугаар хуралдааныг 09 цаг 35 минутад Засаг даргын Тамгын газрын II давхрын хурлын танхимд хийж, Зөвлөлийн гишүүдийн 84.6 хувийн ирцтэй хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аж ахуйн нэгжийн ээлжит тооллого зохион байгуулах тухай	ШИЙДВЭРЛЭСЭН нь: Аж ахуйн нэгжийн ээлжит тооллогоор Жаргалант суманд 2130 аж ахуйн нэгж, 3400 хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг тоолох бөгөөд 1 тоологчид 135 аж ахуйн нэгж, 213 хувиараа хөдөлмөр эрхлэгч оногдож ажлын ачаалал хэт их байгаа тул 7 тоологчийг нэмж гэрээгээр авч ажиллуулах болон тооллогын тайлан, үр дүнгийн ном хэвлүүлэх шаардагдах 3831400 төгрөг (гурван сая найман зуун гучин нэгэн мянга дөрвөн зуу)-ийн эх үүсвэрийг судлан шийдвэрлэхийг Дэд бүтэц хөгжлийн бодлогын асуудал хариуцсан Засаг даргын орлогч (Т.Жаргалсайхан)-д үүрэг болгов.
2	“Тайван амгалан Ховдчууд” аймгийн дэд хөтөлбөр	ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Тайван амгалан Ховдчууд” аймгийн дэд хөтөлбөрийг хэлэлцэх явцад Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусган сайжруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлан, Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулан батлуулахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Н.Ганзориг, тус хэлтсийн ахлах мэргэжилтэн Ч.Эрдэнэбат нарт үүрэг болгов.
3	“Иргэний эрх зүйн боловсрол” аймгийн дэд хөтөлбөр	ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Иргэний эрх зүйн боловсрол” аймгийн дэд хөтөлбөрийг хэлэлцэх явцад Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусган сайжруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлан, Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулан батлуулахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Н.Ганзориг, тус хэлтсийн ахлах мэргэжилтэн Ч.Эрдэнэбат нарт үүрэг болгов.
4	“Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого” дэд хөтөлбөр	ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого” дэд хөтөлбөрийг хэлэлцэх явцад Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусган сайжруулалт хийж, дараагийн хуралдаанд танилцуулахыг Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мягмарсүрэнд үүрэг болгов
5	“Хэрэглэгчийн эрхийг хамгаалах” аймгийн дэд хөтөлбөр	ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах” аймгийн дэд хөтөлбөрийг хэлэлцэх явцад Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусган сайжруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлан, Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулан батлуулахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Ц.Лувсанлхамод үүрэг болгов.
6	“Залуу малчин, тариаланч” аймгийн дэд	ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Залуу малчин, тариаланч” аймгийн дэд хөтөлбөрийг хэлэлцэх явцад Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусган сайжруулалт

	хөтөлбөр	хийж, дараагийн хуралдаанд танилцуулахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Ц.Пүрэвсүрэнд үүрэг болгов.
7.	“Хариуцлагатай тунгалаг төр” аймгийн дэд хөтөлбөр	ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Хариуцлагатай тунгалаг төр” аймгийн дэд хөтөлбөрийг хэлэлцэх явцад Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусган сайжруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболдод үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР